



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/БМ

Улаанбаатар хот

“Жуулчдад зориулсан газрын зураг болон
гарын авлага хэвлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/462 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах зорилгоор Улаанбаатар хотын газрын зураг болон “Улаанбаатар жуулчны хөтөч” гарын авлагыг хэвлүүлж түгээх ажлыг хариуцан зохион байгуулахыг Мэдээлэл, сурталчилгааны хэлтэс /Д.Жавхлан/-т даалгасугай.

2. Улаанбаатар хотын газрын зураг болон гарын авлага хэвлүүлэхэд шаардагдах төсвийг хавсралт ёсоор баталсугай.

3. Улаанбаатар хотын газрын зураг болон гарын авлага хэвлүүлэхэд шаардагдах 34,700,000 /гучин дөрвөн сая долоон зуун мянга/ төгрөгийг Нийслэлийн 2017 оны төсөвт тусгасан “Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болгох арга хэмжээний зардал”-аас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТСҮХ

1150590209

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 06 сарын 01
өдрийн 01 дугаар тушаалын хавсралт



ГАЗРЫН ЗУРАГ БОЛОН ГАРЫН АВЛАГА ХЭВЛҮҮЛЭХ ТӨСӨВ


2017 оны 06 дугаар сар 21

Улаанбаатар хот


№	Зардлын зүйл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Улаанбаатар хотын газрын зураг	10,000	750₮	7,500,000₮
2	"Улаанбаатар жуулчны хөтөч" гарын авлага	6,800	4,000₮	27,200,000₮
НИЙТ ДҮН				34,700,000₮

--ooOoo--

ХЯНАСАН:
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

 Б.БАТБААТАР

ТӨСӨВ ЗОХИОСОН:
ОЛОН НИЙТИЙН ХАРИЛЦАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

 Г.АЗЖАРГАЛ